

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-23
	1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	3-23

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 14-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 14 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг;
Тасалсан: Н.Алтанхуяг, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Ц.Сандаг-Очир.

Нэг. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, Монголын хуульчдын холбооны гишүүн Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ш.Раднаасэд, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монголын хуульчдын холбооны гишүүн Б.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ш.Раднаасэд, Ш.Адъяаа нар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 55 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.МӨНХБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДӨР
/ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг ирье.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Л.Мөнхбаатар ирсэн, Ш.Адъяаа гишүүн ирсэн, Э.Бат-Амгалан гишүүн ирсэн, С.Бямбацогт гишүүн ирсэн, Б.Дэлгэрсайхан гишүүн чөлөөтэй, Ц.Мөнх-Оргил гишүүн ирсэн, Ц.Мөнхцэцэг гишүүн өвчтэй, Х.Нямбаатар гишүүн ирсэн, Б.Пүрэвдорж гишүүн ирсэн, Ш.Раднаасэд гишүүн ирсэн, Ц.Сэргэлэн гишүүн ирсэн, Н.Учрал гишүүн ирсэн, Д.Цогтбаатар гишүүн ирсэн, Б.Энх-Амгалан гишүүн хүрэлцэн ирсэн байна. Мөн Б.Энхбаяр гишүүн ирсэн байна. Ингээд ирц бүрдсэн байна. Байнгын хорооны ирцийг танилцаад дууслаа.

Байнгын хорооноор хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр нэг асуудал хэлэлцэнэ. Энэ нь Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа. Засгийн газар 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг нь шийднэ.

Улсын Их Хурлын даргын захирамж гарч нэн яаралтай горимоор хэлэлцэх захирамж гарсан тул өнөөдөр Байнгын хорооны ээлжит бус хурлыг хуралдуулан уг асуудлыг хэлэлцэж байгаа гэдгийг гишүүдэд бас танилцуулъя.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар сайдын микрофоныг өгөөрэй.

Х.Нямбаатар: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төрийн бүтээмжийн сэргэлтэд авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах зорилт, арга хэмжээ тусгагдсан.

Дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцод нийцүүлэх үүднээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангид Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцод нийцүүлэн халдашгүй бүрэн эрхээр халхавчлан хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээдэггүй, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчмыг гажуудуулдаг байдлыг халах зорилгоор хуулиар халдашгүй байдлыг баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг бүрэн эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрх дуусгавар болсны дараа тоолохтой холбоотой нэмэлтийг төсөлд тусгалаа.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тохиолдолд гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгийг хурааж улсын төсөвт төвлөрүүлдэггүй байдлыг халж, уг хөрөнгө, орлогыг хурааж, улсын орлого болгохоор тусгалаа.

Мөн түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасах, өршөөл уучлал үзүүлэхгүй байх, гэмт хэрэгт авлигын гэмт хэргийг хамааруулах нэмэлтийг тусгалаа.

Гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзан оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг оногдуулах эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болголоо.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, тухайлбал, торгох ялын нэг нэгж нь 2 мянган төгрөгтэй тэнцүү байхаар, зарим гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнээс торгох ялыг хасах, хорих ялын хэмжээг нэмэгдүүлэх, нийтийн албанд ажиллах эрх хасах ялыг 2-оос 8 жилийн хугацаагаар, эсхүл нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасах өөрчлөлтийг тусгасан

бөгөөд хорих ялын хэмжээг нэмж байгаатай холбогдуулан зарим авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нэмэгдэнэ гэж ойлгож болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийг бүхэлд нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй байх өөрчлөлтийг тусгахаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгадаг байх өөрчлөлтийг тусгахаар Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулав.

Хуулийн төсөлд ирүүлсэн Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох яамдын саналыг тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар авлигын гэмт хэргийн гаралт буурах, авлига, албан тушаалтантай тэмцэх төрийн бодлого чангарч, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, шударга ёсны зарчим улам бүр баталгаажна гэж үзэж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд процессор, цагдаагийн дэд хурандаа С.Гантулга, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч, доктор, дэд профессор Б.Батзориг нар оролцож байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгье.

Эрүүгийн хууль түүнийг дагалдуулаад нөгөө Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь хамт байгаа юм билээ.

Тийм учраас асуултаа хамтад нь асууж болно гэсэн үг. Тийм. Нэг явна гэсэн үг шүү.

Ш.Раднаасэд гишүүнээр, Б.Энхбаяр гишүүнээр тасаллаа. Ш.Адъяаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адъяаа: Өнөөдөр энэ нөхцөл байдалтай холбогдуулаад нийгэм маш их бухимдалтай. Түүний дотор авлигын энэ асуудалтай холбогдуулах хуулийн зохицуулалт, түүнтэй холбоотой гарч байгаа асуудалтай холбогдуулж өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байна.

Өнөөдөр нийгэм, ард иргэд энэ эрүүгийн хууль тогтоомж, түүнчлэн авлигал авсан албан тушаалтнуудад хариуцлагыг чангатгах, хуулийн ийм шинэчлэл хийх энэ асуудал зайлшгүй гэдэг дээр санал нэг байгаа. Энэ дээр хуулийг яаралтай баталж гаргах нь өнөөдөр нийгэмд шударга ёс, гэмт хэрэг, түүний дотор авлигын гэмт хэргийг шийдэж ирсэн. Энд шинэчлэл хийх, төрд итгэх итгэл, хуульд итгэх итгэл, хууль дээдлэх зарчимд итгэх итгэлийг бас сэргээх ийм ач холбогдолтой гэсэн ойлголттой байна.

Тэгэхдээ энд хууль санаачлагчаас бас ганц хоёр зүйлийг тодруулъя гэж бодож байна.

Монгол Улс өнөөдөр Авлигын эсрэг конвенцид нэгд орсон. Түүнчлэн хүний эрхийн конвенцид нэгдэн орсон. Энэ өнөөдрийн нөхцөл байдалтай уялдуулж, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улсын өмнө Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгагдсан эрхийн, тухайлбал хөөн хэлэлцэх хугацаа, бусад хүний эрхийн асуудлуудыг энэ хуульд ямар байдлаар тусгаж өгсөн бэ гэсэн нэг ийм асуудал байна.

Түүнчлэн энэ хуулийн төслөөс харахад хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг ямар байдлаар шийдэх вэ гэдэг ийм нэг эргэлзээтэй асуудал байна. Түүнчлэн өнөөдөр эрүүгийн гэмт хэргийг шийдэж ирсэн, шийдвэрлэж ирсэн Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хүндрүүлэх нөхцөл байдлыг энэ Эрүүгийн хуулиар тодорхой хэмжээнд шийдэхэд энд бас энэ Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, хууль хэрэглээний үндсэн зарчим. Энэ дээр зөрчигдөх ийм асуудлууд бас энд байж болзошгүй байна.

Хэдийгээр өнөөдөр бид үүссэн нөхцөл байдалд тулгуурлаж яаралтай горимоор өнөөдөр энэ эрүүгийн хууль тогтоомжийг өөрчилж байгаа ч гэсэн бид өнөөдөр хүний эрхийн түгээмэл тунхаглал, түүнчлэн өнөөдөр эрүүгийн хуулийг хэрэглэх, эрүүгийн хэргийг шийдэх энэ үндсэн зарчмаас энд баримтлах зүйлүүд

бас учир дутагдалтай зүйл орж ирсэн байж болзошгүй юм гэсэн ийм гурван асуудал дээр хууль санаачлагчаас тайлбар авъя.

Л.Мөнхбаатар: Ш.Адъяаа гишүүний асуултад ажлын хэсэг хариулья. П.Сайнзориг дарга хариулья. 3 номерын микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ш.Адъяаа гишүүний асуултад хариулья.

Ер нь Монгол Улсад бас энэ авлигалын асуудал нэлээн хүнд дүр зурагтай байна. Авлига гэдэг бол өөрөө эргээд энэ хүний эрхийг зөрчиж байгаа хамгийн том үзэгдэл болчихоод байгаа.

Тэгэхээр үүнтэй тэмцэх ялын бодлогыг чангаруулах, эргээд зохих хэмжээний ял хариуцлагыг үүрүүлэх, үүнээс олж байгаа, гэмт хэрэг, зөрчлөөс олж байгаа хөрөнгийг бас хураах ч гэдэг юм уу, энэ холбогдох зохицуулалтыг тодруулж байгаа нь өөрөө эргээд бас энэ Монгол Улсын ирээдүйгээс хулгайлж байгаа энэ авлигатай тэмцэх, хүний эрхийг хангах хамгийн чухал алхам гэж харж байгаа.

Яах вэ, ер нь зүгээр процессын оролцогч талдаа энэ эрхийг бас анхаарах зайлшгүй шаардлагууд байгаа.

Тэгэхээр бид хэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн суурь зарчимд нийцүүлж авлигалын гэмт хэргийн шинжийг болон холбогдох ял хариуцлагын бодлогыг зохицуулж, бас нийцүүлж орж ирсэн гэж танд хэлмээр байна.

Мэдээж авлигатай тэмцэхэд торгох шийтгэлийг ялын бодлогоос тодорхой гэмт хэргүүд дээр бас хасаж байгаа. Эрх хасах ялыг яг энэ авлига албан тушаалын гэмт хэрэг дээр үйлдсэн гэм буруу нь тогтоогдсон этгээдэд нэлээн чангаруулж буюу бүх насаар нь нийтийн албанд ажиллах эрхийг нь хаах байдлаар хуулийн төсөлд бас оруулж ирсэн.

Хөөн хэлэлцэх хугацааны тухайд асууж байна. Тодорхой жишээ нь юу гэдэг юм практикууд бас тулж байсан. Ер нь тодорхой халдашгүй бүрэн эрхтэй этгээдүүдийг тодорхой гэмт хэрэг шалгах асуудлыг тавьж, бүрэн эрхийг нь түдэлзүүлэх асуудал орж ирдэг. Эргээд энэ тодорхой институциуд нь бас шийдвэр гаргахгүй ч байдаг юм уу ийм зүйлээсээ болоод хөөн хэлэлцэх хугацаа дуусах. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлагад татахгүй байх ч гэдэг юм уу ийм зүйлүүд бас гарсан. Тэгээд энэ байдлыг бид халж хуулиар халдашгүй байдлыг нь баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлээгүй бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа тоолж эхлэхээр ийм холбогдох өөрчлөлтийг хийж байгаа.

Тэгэхээр энэ бүрэн эрхийн халдашгүй байдал гэдэг юм уу, үүний ард нуугдах ийм бололцоо бол одоо байхгүй болж байгаа гэж хэлмээр байна.

Бусад юу гэдэг юм энэ хууль эрх зүйн асуудал дээр товчдоо танд танилцуулахад бас энэ хуулиар тодорхой хэрэг маргаан, авлигын хэрэг маргааныг 22 дугаар бүлгийг бүхэлд нь хялбаршуулсан журмаар шийдэхгүй байх, авлига албан тушаалын гэмт хэрэгт өршөөл уучлал үзүүлэхгүй байх. Эргээд мэдээж бас хөрөнгө хураах албадлагын арга хэмжээг ямар түвшинд яаж хэрэглэх вэ гэдэг тодорхой зохицуулалтуудыг тодотгож энэ дээр оруулж ирж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд хууль хэрэглээний хувьд материаллаг хуулийн хувьд эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан зарчмынх нь дагуу үйлчлээд явна. Процессын хуулийн хувьд бол хууль буцаан хэрэглэх гэдэг юм уу, Таны энэ агуулгын хүрээнд хөндөж асуусан болов уу гэж би ойлгоод процессын хууль дээр хууль буцаан хэрэглэх асуудал үүсэхгүй. Яг энэ хууль батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хялбаршуулсан журмаар хэрэг маргаан шийдэхгүй явна.

Тэгэхээр энэ нөхцөл байдал процессын хууль дээр хууль хэрэглээний янз бүрийн асуудал үүсэхгүй гэж ойлгож байгаа.

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Одоо нөгөө жагсагчдаа л бас хуурч байгаа юм байна даа.

Ийм юм хийгээд ч хэрэг байгаа юм уу. Одоо таван хүний нэрийг зарлаад л. Эд нар хэрэгт холбогдсон гээд. Өнөөдөр Авлигатай тэмцэх газар дээр нь очсон. Та нарыг гэм буруутай гэж бид нар үзээгүй, шалгаагүй байгаа шүү дээ гэсэн хариулт өгч байгаа юм.

Одоо энэ жагсагчдаа хуурсан юм дахиад энэ дотор явж байна. Одоо энэ 5 жил хүртэлх ялтай болбол хохирлоо төлчихвөл ялаас чөлөөлнө гээд 1.2, 6.7.1 дэх хэсэг ерөнхий заалт дээрээ ингээд хийчхэж байгаа юм.

Тэгээд бүгдийг нь 5 жил болгочихсон. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах 22.1 нь 5 хүртэлх жилтэй. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих 5 хүртэлх жилтэй.

Тэгээд ерөөсөө хохирлоо төлчихсэн би гэдэг байдлаар ингээд чөлөөлж байгаа юм байна л даа.

Энэ хүмүүс гудамжинд олон сар жагссаны нэмэр ч алга. Олон өдөр жагссаны. Бүр сайн жагсах хэрэгтэй юм байна. Үнийг бүр сайн застал.

Тэгээд одоо энэ дээр хар. Та нар энэ 1 дүгээр зүйлээ унш даа. Хуулиар халдашгүй байдлыг нь баталгаажуулсан албан тушаалтны бүрэн эрхийг зогсооно гэж байгаа юм. Түдгэлзүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацааг нь зогсооно гэж байгаа юм.

Энэ шууд түдгэлзүүлдэг болго л доо. Тэгвэл. Үнэхээр улс төрийн хүсэл зориг байгаа юм бол. Энэ нүүрснийхээ хулгайтай тэмцэх.

Тэгээд их хэмжээний авлига гэдэг 100 сая төгрөг. 100 мянган нэгж гээд 100 сая төгрөг. Хэдэн арван сая долларын юм ярьж байна шүү дээ. Энд. Хэдэн арван сая долларын юм ярьж байна шүү дээ.

Ийм байдлаар ингэж хуурч болохгүй ээ. Ард түмнийг. Энэ хөөн хэлэлцэх хугацаа гэж. Анх оруулсан өөрчлөлтийг та нар хийсэн шүү дээ. Х.Нямбаатар аа. Тийм. Тэр хэн билээ? Б.Бат-Орших билүү? Прокурорын. Одоо энэ Б.Батзориг тэр ажлын хэсэгт байсан уу, яалаа.

Хөнгөн гэмт хэрэг дээр ял шийтгэх хугацаа дуустал гэж явсан миний өөрчлөлтийг та нар өөрчлөөд, байхгүй хойгуур өөрчилж оруулаад араас нь Эрүүгийн хуульд хийгээд. Одоо тэгээд хөөн хэлэлцэх хугацааг Ш.Раднаасэд хийсэн гээд ингээд явдаг.

Үүгээр нэг ч албан тушаалтан ял шийтгэгдэхгүй юм байна. Би хохирлоо төллөө. Учруулсан хохирлоо нөхөн төллөө. Эсвэл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэж байгаа юм. Тэгэх юм бол хорихоос өөр төрлийн ял оногдуулна. Сонгож гэсэн. Бүр сонгож оногдуулна гэж байгаа юм.

Эсвэл хорих ял оногдуулахгүйгээр 5 жил, түүнээс бага хугацаагаар тэнсээд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэнэ гээд.

Ингэж тэмцэх гэж байгаа бол энэ чинь л тэмцэл биш ээ. Энэ ард түмнийг хуурч байна. Та нар. Ийм юм хиймээргүй байна. Энэ үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

Энэ хөрөнгө орлогын мэдүүлэг, энэ сайд нарын хөрөнгө орлогын мэдүүлэг яагаад өсөөд, энэ Их Хурлын гишүүд яагаад өсөөд. Би маргааш гарч энэ бүх Их Хурлын гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлэг сүүлийн гурав, дөрвөн жилээр нь шалга гэж асуудал тавья гэж бодож байгаа. Асуудал тавья.

Энд хадгалчихдаг. Авлигатай тэмцэх газар үздэггүй. Одоо тэгээд яах вэ. Авлигатай тэмцэх газар үздэг болох юм байна л даа. Өгсөн даруйд нь шалгадаг байх ёстой.

Тэгээд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байна. Энэ чинь хөрөнгө орлогын мэдүүлэг татвар төлсөн орлого мөн ч юм уу, биш ч юм уу. Одоо ингээд гараад ирлээ гэнгүүт өө за за.., би үүнийгээ төлчихье. Ингээд чөлөөлөгдөөд явах юм байна.

Ингэж хуульд өөрчлөлт хиймээргүй байх юм.

Энэ ард иргэд чинь өөр юм яриад жагсаад байна шүү дээ. Та нар бол яах вэ 5 нэр гаргаад шидчихсэн. Одоо энэ 5 нь ингээд нийгмийн дунд нийгэм яллаад явчихна. Тэгээд хооронд нь сайхан үлдчихнэ бид нар гээд алга ташаад эндээ сууж байгаа шүү дээ.

Энэ Эрүүгийн хуулийн өөрчлөлтийг ингэж хиймээргүй байна. Энэ Ардчилсан намын бүлэг чадвартай чансаатай бол энэ дээр та нар завсарлага аваад үнэхээр тэмцэх хүсэл зоригтой байгаа бол ажиллаач.

Ийм байдлаар ингэж хийх юм бол энэ бүр өмнөхөөсөө дордуулчихсан байна.

22.1 дотор байсан тэр торгуулийг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсэг П.Сайнзориг дарга эхэлж хариульъя. Дээр нь Х.Нямбаатар сайд нэмж хариульъя.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын гишүүн ч гэдэг юм уу, ер нь хуулиар тодорхой халдашгүй байдалтай энэ албан тушаалтны асуудал бол яг энэ Эрүүгийн хуулийн асуудал биш байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүдийнх бол мэдээж Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хууль, өөр бусад байдлаар бас халдашгүй байдлыг нь тогтоосон ийм хуулиуд байгаа. Тэр хуулийнхаа хүрээндээ тодорхой хэмжээнд яригдах асуудал. Яг энэ Эрүүгийн хуулиар шийдээгүй ийм зүйл байгаа.

Энэ 6.7 буюу гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх албадлагын арга хэмжээ гэж байдаг. Энэ дээр зүгээр тодотгол байгаа. Яг энэ хуучин хэвээрээ.

Энэ тодотголууд нь ямар асуудал байна гэхээр учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал болон мөрдөн шалгах ажиллагаанд шуурхай явуулж, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн бол гэж л тодотгож оруулж өгч байгаа. Дэмжлэг үзүүлээгүй бол энэ юмнуудыг бас энэ хөнгөрүүлэх нөхцөл байдлуудыг эдлүүлэхгүй шүү гэдэг агуулгаар тодотгож оруулж ирсэн.

Түүнээс биш одоо яг мөрдлөн шалгах ажиллагааг явуулж явуулж дуусаад шүүхийн шатанд оронгуутаа би одоо ингээд юу яая, ийм зүйлүүдийг хэлээд байна. Хөнгөрүүлж өгөөч ээ гэдэг зүйл их байдаг.

Тэгэхээр нэгэнт мөрдөгч энэ үйл ажиллагааг хийгээд дууссан хойно энэ хөнгөлөлтийг үзүүлэхгүй шүү гэдэг үүднээс л. Одоо яг мөрдөн байцаалтын шатанд харин хамтарч ажиллаж дэмжлэг үзүүлэх юм бол энэ хөнгөлөлт, чөлөөлөлт бас байж болох юм. Энэ бол зөвхөн авлигын хэрэг биш. Нийтлэг байдлаараа байгаа. Одоо ч байгаа зохицуулалт гэдгийг гишүүнд хэлмээр байна.

Их хэмжээний хахууль авах гээд байгаа. 100 сая төгрөг.

Тэгэхээр бид гэмт хэргийн шинжийг тодорхойлж өгч байгаа. Яг их хэмжээний хахууль авах гэдгийг бас юу гэж тодорхойлох вэ гэдэг асуудал байхгүй учраас тайлбараар 100 сая төгрөг, түүнээс дээш гэж байгаа.

Хорих ялын хувьд нэлээн чанга. 5-аас 12 жил байгаа. Оногдуулахаар ингээд оруулж ирж байгаа.

Тэгээд үүнийг улс төрд нөлөө бүхий болон зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдэх юм бол 12-оос 20 жил гэсэн Эрүүгийн хуулийг нэлээн чангаруулсан байдлаар оруулж ирж байгаа гэдгийг хэлмээр байна.

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар хариулт яах юм уу? Эхлээд Ш.Раднаасэд. Яах юм? Х.Нямбаатар сайд хариулъя. Дараа нь Ш.Раднаасэд гишүүн тодруулж асууна.

Ш.Раднаасэд: Ш.Раднаасэд гишүүнийг би бухимдалтай байгааг маш сайн ойлгож байна.

Энэ дээр бид ч гэсэн бас эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хууль дээдлэх зарчмыг баримталдаг улсад хэн нэг хүнийг шалгахдаа ямар хэрэгт холбогдуулан шалгаж байгааг өөрт нь танилцуулж тайлбарладаг энэ зарчим байх ёстой гэдэг дээр би 100 хувь санал нэг байна.

Харин Эрүүгийн хуулийг хэлэлцэхдээ сэтгэл хөөрлөөр юм уу, тухайн тэр агшинд төрсөн уур бухимдлаараа Эрүүгийн хуулийн хэлэлцэх эсэхийг шийдэхдээ тийм субъектив байдлаар хандаж болохгүй гэж бодож байгаа юм.

Энэ Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийг бүхэлд нь хөндсөн. Та Хууль зүйн байнгын хорооны гишүүний хувьд, Улсын Их Хурлын гишүүний хувьд 22 дугаар бүлэгтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргах эрх нь танд нээлттэй байгаа.

Бид конвенцийн зарчмуудыг барихаас гадна Эрүүгийн хуулийнхаа ерөнхий тэр хайрцаг объёмдоо баригдаж Эрүүгийн хуулийн энэ 22 дугаар бүлгийн өөрчлөлтийг оруулж ирсэн.

Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг дээр бид 22.1 болон хээл хахууль авах зүйл ангиуд дээр торгуулийн ял болон юуг бүхэлд нь авч хаяж байгаа юм. Хэрэг хялбаршуулан шийддэг зарчмыг бүхэлд нь авч үзэж байгаа. Авч үйлчлэхээргүй болгож байгаа.

6, 7 гэдэг бол Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6, 7 дээр ойлгомжтой байлгах үүднээс мөрдөн шалгах ажиллагааг хурдан шуурхай явуулахад дэмжлэг үзүүлсэн гэдэг үйлдлийг нь тодотгож өгч байгаа юм.

Авлигатай тэмцэх газар 2020, 2021 оны статистикаар 180-аас 200 орчим авлигын хэргийг жил болгон шийдэж байгаа юм.

Таныг Авлигатай тэмцэх газар комиссароор ажиллаж байх үед жилд дунджаар 3-аас 4 авлигын хэргийг шийдэж байсан бол өнөөдөр энэ шинэ үйлчилж байгаа, 5 жил гаруй үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн үр нөлөө, үр дагавар, авлигатай тэмцэх байгууллагын тэр хүсэл эрмэлзлийг энэ статистик тоо харуулах болов уу гэж бодож байгаа.

Жилд 200 орчим хэрэг шийдэж, 200 орчим тэрбум төгрөгийн гэмт хэргийн улмаас үйлдсэн тэр хор хохирлыг улсын орлого болгох, төвлөрүүлэх энэ ажлыг эрчимтэй явуулж байгаа гэдгийг бас нэмж хэлье.

Та үндэслэлээ маш тодорхой гаргах хэрэгтэй. Ш.Раднаасэд гишүүн. Би дахиад хэлье. Бид өөрсдөө хуульч гишүүд. Хууль зүйн байнгын хорооны мэргэжлийн байнгын хороо Эрүүгийн хууль, хүний амьдрал, амь насыг дэнсэлдэг, эрх, эрх чөлөөг нь хязгаарлалт хийдэг хамгийн том хуулийг хэлэлцэж батлахдаа тухайн цаг үед төрсөн сэтгэл хөөрөл, энэ хандлагаараа хандаж болохгүй.

Та яг бид нарын оруулж ирсэн төсөл, өмнөх төслөө ингэж дордуулсан гэдгээ та яг тодорхой заалт хийх хэрэгтэй. Нийтийн албан тушаал хаших эрхийг бид бүх насаар нь нэмэгдэл шийтгэл болгож оруулж ирж байгаа.

Тэгэхээр энэ зохицуулалт болгоны гол цаад агуулга нь авлигатай хийх тэмцэл, хүсэл эрмэлзэл байна уу, үгүй юу гэдгийг л бид энэ хууль яаж, хэрхэн батлагдахаас харагдана.

Тэгэхээр хүмүүсийн гол бухимдал бол 40 сая төгрөгөөр өчнөөн олон тэрбум төгрөгийн авлига, хээл хахууль авсан, албан тушаалаа урвуулан ашигласан нөхөр нь эцэс сүүлдээ хэргээ хялбаршуулан шийдээд 40 сая төгрөгөөр торгуулаад байна гэдэгт иргэд олон нийт бухимдалтай байгаа.

Тийм учраас Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийг бүхий л гэмт хэрэг дээр хэрэг хялбаршихгүй. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой төрлийн тэр хорих ялыг оногдуулдаг тэр ердийн зарчим үйлчилнэ. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгээс бусад бүлэг дээр хэрэг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдэг тогтолцоо үйлчилнэ. Ингэхдээ 6, 7-гоо удирдлага болгож явна л гэдэг ийм өөрчлөлтийг оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүн тодруулж асууя.

Ш.Раднаасэд: 22.1 дээр хуучин 40 сая гэдэг үгийг нь л авч хийсэн байна шүү дээ. Тэгээд нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хасна. 1-ээс 5 жилээр зорчих эрхийг хязгаарлана. Эсхүл 1-ээс 5 жил хүртэл хугацаагаар хороно. Энэ хуучин байсан л юм шүү дээ.

Энэ сонгох санкцийг чинь шүүх яаж хэрэглэж байна гэхээр одоо бол торгохоо болиод бүр 2-оос 5 жилээр ингээд төрд ажиллахыг чинь хаслаа. 1-ээс 5 жилийн хугацаагаар зорчих эрхийг чинь хязгаарлалаа. Гэртээ сайхан амар гээд ингээд.

Тэгээд энэ 10, 10 сая долларын хэрэг яриад байгаа энэ сайд нар чинь яах юм. Тэгээд юм боллоо гэхэд ингээд гэртээ 5 жил сууж байгаад гарчих юм уу? Эсвэл төрийн албанд 5 жил ажиллахгүй байж байгаад явуулчих юм уу? Нөхцөл байдал чинь ийм л байна шүү дээ.

Үгүй ээ тэгээд хорих юм, ялын дээд хэмжээ чинь 5 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон бол, юмаа төлчихсөн бол та албадлагын арга хэмжээ авахгүй. Хорих ял өгөхгүйгээр ингээд шийдчихнэ гээд энд 3 дугаар зүйлийн чинь 1-д.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүний асуултад П.Сайнзориг дарга хариульъя. 3 номерын микрофон өгөөрэй.

22.1 дүгээр зүйлийн яг үндсэн бүрэлдэхүүнийг яриад байна л даа. Энэ дээр мэдээж өөрчлөлт нь торгох ялыг хасаж байгаа нь үнэн.

Мэдээж Ш.Раднаасэд гишүүний ярьж байгаа тэр хэдэн арван тэрбумын авлигал авч байгаа ч юм уу, хэдэн арван тэрбумын ашиг сонирхолд орооцолдож байгаа хүн бол энэ 22 дугаар зүйлийн 1 дэх үндсэн бүрэлдэхүүнээр явахгүй шүү дээ.

Энэ өөрөө эргээд 22.1 буюу их хэмжээний хохирол учруулсан болон улс төрд нөлөө бүхий этгээд буюу хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүнээрээ л зүйчлэгдэнэ. Энэ дээрээ бид холбогдох ялуудыг чангалж оруулж ирж байгаа. Тэр дээр эрх хасах ялыг нь төрд гэхгүйгээр бүр өргөжүүлж, нийтийн албанд бүх насаар нь ажиллах эрхийг нь хязгаарлах ийм байдалтай оруулж ирж байгаа.

Тэгэхээр мэдээж юу гэдэг юм энэ авлигыг гэдэг юм уу, ашигт сонирхол, эрх мэдлээ урвуулан ашиглаж байгаа үйлдэл болгон, нөхцөл байдал болгон бас өөр өөр байгаа.

Тэгэхээр энэ юу гэдэг юм, тэр хэдэн арван тэрбумын ашиг сонирхлын зөрчил гаргаж байгаа зүйлүүд бол энэ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт ойлгомжтой байна. Б.Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: Баярлалаа. Би хэд хэдэн асуулт асууя.

Энэ хууль маань бас нэлээн шуурхай орж ирж байгаа. Үдээс өмнө Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдээд Улсын Их Хуралд сая өргөн баригдаад, сая Хууль зүйн байнгын хороо гэнэт зарлагдаад хуралдаж байгаа.

Тийм учраас уншиж танилцах хугацаа нэлээн давчуу байсан шүү гэдгийг хэлчихье.

Тийм учраас бас мэдэхгүй юм асууж байж магадгүй шүү. Тэгвэл бас ажлын хэсэг ойлгож хүлээж аваарай гэж.

Нэгдүгээрт нь, Улсын дээд шүүх хэргийг давж заалдах шатны журмаар шийдвэрлэх асуудал өмнө нь нэг орж ирсэн байсан. Энд тийм юм байгаа юу гэсэн асуулт байна. Нэг.

Хоёрт, хэрэг маргааныг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар би бол энэ прокурорын байгууллагаас уг нь ажлын хэсэгт байлцуулж чуулган дээр энэ асуудлыг хэлэлцэх үед прокурорын байгууллагаас асуулт асуумаар байна. Одоо бол яах вэ, энэ Х.Нямбаатар, П.Сайнзориг хоёр чинь яг хэрэг шалгадаг хүмүүс биш байхгүй юу. Нөгөө хуулиараа. Тэгэхээр энэ хоёроос асууж чадахгүй.

Тэгэхээр би одоо энэ Б.Батзориг доктороос л асууя даа. Гэмт явдал судлаач. Одоо яг криминологич гэдгээр нь би асууя. Одоо яг хөндлөнгийн хараат судлаач гэдгээр нь асууя.

Бид энэ хялбаршуулсан журмаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх асуудал 2015 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар орж ирсэн. Тийм ээ. Тэгээд асуудлыг анх оруулахдаа санаа нь юу вэ гэхээр нуугдмал байдлаар үйлдэгддэг зохион байгуулалттай том гэмт хэргүүдийг илрүүлэх зорилгоор оруулсан.

Бид кинон дээр үздэг шүү дээ. Манай Жэнкогийн “Загалмайлансан эцэг” кинон дээр үздэг. Тийм ээ. Тэр кинон дээр бол тэр нөгөө Дон Корлеоне буюу тэр мафийн толгойлогчийг яаж барих вэ гэхээр тэр гар хөлүүд нь хэрвээ чи толгойлогчоо илчлэх юм бол чиний өөрийн чинь ялыг хөнгөрүүлж авч үзье. Чи толгойлогчоо илчилбэл чамтай ял наймаалцъя л гэсэн үг байхгүй юу. Тэгж байж цаад тулыг нь барих гээд байгаа байхгүй юу. Тулыг нь. Тийм зорилгоор энэ хэрэг хялбаршуулах журмаар шийддэг асуудлыг оруулж ирсэн юм.

Тэгэхээр энэ оруулж ирснээс хойш авлигын гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн үү? Энэ авлигын гэмт хэргийг илрүүлэхэд энэ хялбаршуулсан журам гэдэг маань үр нөлөө өгсөн, өгч байгаа зүйл байна уу, байхгүй юу? Байна уу, байхгүй юу?

Иргэд бол одоо ингээд савах гээд байна. Бид хууль тогтоогчид. Энэ бол шинжлэх ухаан шүү. Эрүүгийн эрх зүй гэдэг бол. Ялангуяа гэмт явдал судлал гэдэг бол цэвэр эрүүгийн эрх зүй. Хүчингийн гэмт хэрэг дээр алаад хядаад байя. Одоо хүчиндсэн хүмүүсийг алаад хядаад байя гээд ял өгчихөөр эсрэгээрээ хүчиндчихээд бүр хэргээ илрүүлэхгүй гээд алчихдаг гэж байгаа байхгүй юу.

Цаазын ялтай учраас. Нөгөө хүчиндүүлээд өнгөрөх байсан хохирогчийг бүр амь насыг нь бүрэлгэж дуусдаг ийм хортой юм байна лээ.

Тэгэхээр би энэ авлигын гэмт хэрэг дээр асуух гээд байгаа байхгүй юу. Хэрэг хялбаршуулахгүй ээ гээд бид шийдчихлээ. Авлигын гэмт хэрэг дээр. Нөгөө жагсаж байгаа ард иргэдийнхээ шаардлагын дагуу. Яг хэрэг дээрээ үүний чинь гороор нөгөө этгээд хаашдаа би толгойлогчоо илчлээд миний ял хөнгөрөхгүй юм чинь гэхээр бүр дуугүй болчих юм биш үү. Бүр авлигын хэрэг чинь илрэхгүй болчих юм биш үү гэсэн ийм асуулт байна.

Л.Мөнхбаатар: Х.Нямбаатар сайд эхний асуултад хариулъя. Хоёр дахь асуултад нь манай Б.Батзориг доктор хариулъя.

Б.Энхбаяр гишүүн ээ, ингэнэ. Маргаашийн хуралдаанд Улсын дээд шүүхийн шүүхээс, мөн Улсын ерөнхий прокурорын төлөөллийг оролцуулна. Нэгдсэн чуулганд. Тэр үед та асуултаа асуугаарай. Энэ чухал асуудал өндөр тавиад байгаа шүү дээ.

Тэгээд үүнтэй холбоотой тоон мэдээ, статистикууд. Дээр нь одоо нөгөө гэмт хэргийн шалтгааныг судлах хүрээлэн маань ер нь прокурорын дэргэд бий юу. Татан буулгасан уу.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэн гэж олон жил ажиллаж ирсэн энэ криминологийн хүрээлэн маань хаана явна. Түүнтэй холбоотой тухайн асуудлыг эрхэлж байгаа, хариуцаж байгаа албан тушаалтнууд байх юм бол маргаашийн хуралдаанд М.Үнэнбат ахлах зөвлөх оруулаарай. Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцуулна шүү.

Х.Нямбаатар сайд асуултад хариулъя.

Х.Нямбаатар: Би Байнгын хорооныхоо гишүүдэд нэг зүйл хэлэх гэсэн юм.

Хэдүүлээ нөгөө шүүх байгуулах хуулийг Засгийн газраас оруулж ирэхээсээ өмнө Их Хурлын гишүүдтэйгээ, тэр дундаа Хууль зүйн байнгын хороон дээрээ нэлээн сайн ярилцъя. Өөрөөр хэлбэл бид нар хуучин засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түшиглэсэн шүүхийн тогтолцоотой яваад байгаа юм. Баянзүрх дүүргийн эрүүгийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн эрүүгийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн анхан шатны шүүх, Багахангай дүүргийн эрүүгийн анхан шатны шүүх, иргэний анхан шатны шүүх гээд.

Тэгэхээр бид 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр шүүхийг байгуулахдаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг түшиглэхээс гадна хэргийн ачаалал, газар нутгийн ойр зарчмыг баримталж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарчмаар байгуулахаас гадна тойргийн зарчмаар байгуулах боломжтой гэдэг Үндсэн хуулийн боломжийг нээж өгсөн юм.

Тэгэхээр бид нэг тийм том шүүх байгуулах, хэргийн харьяалал шийдэх, энэ шүүхийн барилга байгууламжийг шийдэх том суурь бодлогын танилцуулгыг Хууль зүйн байнгын хорооны гишүүдэд уг нь энэ ондоо багтаж нэг танилцуулах, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй бас хамтарч ажиллах ийм ажлууд байгаа юм.

Тэгэхээр энэ асуудал хөндөгдөх хүртэл Б.Энхбаяр гишүүн ээ, ямарваа нэгэн байдлаар хэргийн харьяалалтай холбоотой зохицуулалтыг бид хөндөхгүй явъя гэж байгаа юм. Тийм.

Энэ удаагийн нэмэлт, өөрчлөлт дээр энэ зохицуулалтыг бид оруулж ирээгүй байгаа.

Тэгэхээр цаашид бид ер нь үүнийг оновчтой шийдмээр байгаа юм. Би нэг жишээ аваад байгаа шүү дээ. Багануур дүүргийг тойроод Төв аймгийн хэдэн сумдууд байгаа. Хэнтий аймгийн сумдууд байгаа. Гэтэл хэргээ шийдүүлэх гээд эрүүгийн болон иргэний анхан шатны шүүх рүү явахын тулд Багануур дүүргийг даваад Зуунмод хотод очиж байгаа юм. Төв аймгийн шүүхэд очсоноор асуудал шударга ёс тогтоно, Багануур дүүргийн шүүхэд газар нутгийн ойр зарчмаараа шийдэгдэхэд шударга ёс тогтохгүй гэдэг ийм ойлголт бол байж болохгүй.

Нөгөө талдаа бид энэ шүүхийг байгуулахдаа их оновчтой хуваарилмаар байгаа юм. Булган аймаг Эрдэнэт хот хоёр хоорондоо 60 километр засмал замаар холбогдсон. Хоёулаа Захиргааны хэргийн анхан шатны шүүхтэй. Жилд заримдаа 3-аас 4 хэрэг шийдэж байна. Нөгөө шүүх нь хоёулаа захиргааны бүтэн бүрэлдэхүүнтэй байгаад байдаг. Үүнийг бид эргэж энэ татвар төлөгчдийн мөнгөөр шүүхийг байгуулахдаа их оновчтой байдлаар шийдмээр байна.

Давж заалдах шатны шүүх. Одоо нэг аймаг дээр, зарим аймгуудад 5, 6 шүүх байгаа. Эрүүгийн анхан шатны нэгдүгээр шүүх, эрүүгийн анхан шатны хоёрдугаар шүүх, иргэний анхан шатны нэгдүгээр шүүх, хоёрдугаар шүүх, давж заалдах эрүүгийн шүүх, иргэний давж заалдах шүүх, захиргааны шүүх. Ингээд тоолоод үзэхээр зарим аймаг дээр 7 шүүх байж байх жишээтэй.

Тэгэхээр цаашид бид эдгээр шүүхүүдийг хэрэг маргааныг харьяалан шийдвэрлэхдээ илүү ухаалаг смарт байдлаар шүүх байгуулах хуулийн саналыг оруулж ирэхдээ би мэргэжлийн Байнгын хорооны гишүүдтэй эхэлж сайн зөвшилцье гээд дээрээс хойш хэлээд байгаа.

Ийм учраас энэ удаа ийм зүйл орж ирээгүй. Б.Батзориг доктор юуг хариулъя. Нөгөө криминологи үр дагавар, гэмт явдалтай тэмцэх тал дээр албан тушаалын гэмт хэргийг хялбаршуулсан нь статистик хөндмөөр байна. Тийм ээ. Сүүлийн жилүүдийн статистикийг.

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр гишүүний асуултад Б.Батзориг доктор. 4 номер уу. Б.Батзориг доктор хариулъя. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлүүдийн талаар мэргэшсэн ийм хуульч байгаа.

Б.Батзориг: Тэгэхээр яг статистик тоо байхгүй байна. Гэхдээ сүүлийн үед шийдвэрлэгдэж байсан авлигын хэргүүдийг уншсан. Та бүхэн ч гэсэн өөрсдөө хэвлэлээр харж байгаа байх.

Улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн үйлдсэн, мөн өндөр албан тушаалтнууд оролцсон авлигын хэрэг дээр нэг өгүүлбэр явдаг. Хэргээ сайн дураараа хүлээсэн гэж.

Өөрөөр хэлбэл тэр хүн хэргээ хүлээнэ гэдэг чинь би өөрөө ийм хэрэг үйлдсэн гэхээсээ илүү ийм ийм хүмүүстэй би хамтарч үлдсэн гэдэг энэ тохиолдолд хялбаршуулсан журам ажиллаж байгаа.

Миний хувьд, судлаачийн хувьд энэ заалт хэрвээ ажиллаад хялбаршуулсан журамд авлигын хэрэг дээр үйлчлэхгүй бол шүүх дээр байдаг гал прокурор дээр очих ийм эрсдэлтэй.

Асуудал нь юу вэ гэхээр хялбаршуулаад торгох ял аваад байгаад нь л хүмүүс бухимдаад байгаа болохоос биш яг хялбаршуулсан дээр бол бас өөр байгаа байх. Яах вэ, тусгай зохицуулалт хийгээд 15 жил хорих ялтай гэмт хэрэг дээр, ялангуяа авлигын хэрэг дээр хялбаршуулсан журмаар шийдээд. Дээрээс нь гэмт хэрэг нотлоход дэмжлэг үзүүлсэн ийм агуулгатай байх юм бол хорих ялыг нь жоохон багасгаж өгдөг, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үздэг ийм заалт бол энэ 17.1 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг, 7 8 дахь хэсгүүд дээр орж ирж байгаа юм л даа. Үүнийгээ боловсронгуй болгоод ирчихвэл бас харьцангуй гайгүй байх.

Тэр чигээр нь хялбаршуулсан журам ажиллахгүй байх юм бол Б.Энхбаяр гишүүний хэлдэг шиг ийм эрсдэл бол үүснэ.

Тэгэхээр ер нь сүүлийн үед авлигын гэмт хэрэг илэрч байгаа нь энэ зүйл заалт, өөрөөр хэлбэл хамтран ажиллах гэрч, өөрөөр хэлбэл бусдын гэмт хэргийг нотлоход, дээрээс нь хэргийн хүлээх заалт. Энэ хоёр заалт ажиллаж байгаа нь бас тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа байдал харагдаж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Б.Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Авлигын гэмт хэрэгт өршөөл уучлалт үзүүлэхгүй гэдэг заалт орж ирж байгаа юм байна. Би өршөөл дээр нь асуудал алга.

Уучлал бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд заагдсан бүрэн эрхийн асуудал байдаг. Энэ бүрэн эрхийг нь Улсын Их Хурал хуулиар л хязгаарлах гэж байна л даа.

Тэгэхээр авлигачдыг Ерөнхийлөгч нэг уучлаад байх нь юу бол гэж нэг талаасаа бодож байгаа юм. Нөгөө талаасаа байна шүү дээ одоо манай Цогтоо сайд сайн мэдэх байх. Энэ улс орны төрийн тэргүүнүүд чинь бас том томоохон

хэрэгтнүүдээ бас солилцдог шүү дээ. Харилцан уучилж. Сая энэ өнгөрсөн 7 хоногт Орос чинь нөгөө зэвсгийн алдарт наймаачнаа Америкийн сагсан бөмбөгчнөөр солилцлоо шүү дээ.

Тэгэхээр энэ цэвэр дипломатын асуудал байгаад байгаа байхгүй юу бас. Хоёр том улсуудын хооронд хэрэгтнүүдээ солилцдог. Энэ эрхт нь бас энэ Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлах.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: П.Сайнзориг дарга хариулъя.

Яах вэ, өршөөл, уучлал гээд энэ хоёр зүйл байгаа шүү дээ. Тэрийг чинь Эрүүгийн хуульд одоо яг ямар ч зүйл анги дээр өршөөл, уучлал үзүүлэхгүй ээ гэдэг заалт байгаа. Нэг заалт байгаа. Тиймээ. Энхтайваны эсрэг гэмт хэрэг ч билүү. Лав түүн дээр байгаа. Тэр дээр нэмээд энэ 21 дүгээр зүйлийг нэмэх гэж байна шүү дээ. Тийм ээ. Авлигын эсрэг зүйлийг нэмэх гэж ойлгоод байгаа. Энэ талаар тодорхой тайлбар өгчих.

Д.Сайнзориг: Л.Мөнхбаатар дарга бараг хариултыг хэлчихлээ.

Эрүүгийн хуульд заасан Эрүүгийн хуулийн ерөнхий ангид хүн төрөлхтний болон бүх насаараа хорих ял оногдуулах гэмт хэрэг дээр өршөөл, уучлал ерөөсөө үзүүлдэггүй.

Хоёрдугаарт, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхийг тодорхой хуулиар нарийвчлан зохицуулах асуудал байгаа. Хэрэв энэ өршөөл, уучлал үзүүлэх асуудлыг задгай хашилтгүйгээр эдлэх юм бол, тодорхой хязгааргүйгээр эдэлнэ гэж үзэх юм бол магадгүй авлигал, мөнгө угаах гэмт хэрэг дээр уучлал үзүүлснээр Монгол Улс тэр чигтээ олон улсын хориг арга хэмжээнд орох ийм зүйлүүд ч бас гарч болно.

Тэгэхээр ийм эрсдэлүүдийг ер нь хааж өгөх, хуулиар нэг мөр тодорхой болгох нь зөв. Тэгэхээр энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэж байгаа хүндээ ч гэсэн энэ эрхийг хэрэгжүүлэх хүрээ хязгаар нь бас ойлгомжтой байх нь зөв болов уу гэдэг үүднээс бид энэ Эрүүгийн хуулийн ерөнхий анги дээр бас орж ирсэн.

Засгийн газраас боловсруулж байгаа Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр ч бас энэ асуудал бас тус.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Ш.Раднаасэд гишүүнээр тасаллаа. Ш.Адъяаа гишүүнээр тасаллаа. Б.Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Манай Эрүүгийн хууль цаазаар авах ялыг халахаас өмнө нийтдээ 6 гэмт хэрэг дээр ялын дээд хэмжээ оноодог байсан. Цаазаар авах ялыг. Цаазаар явах ялыг халснаас хойш одоо манай ялын дээд хэмжээ бүх насаар нь хорих ял болсон байгаа.

Энэ ялыг 5 гэмт хэрэг дээр хэрэглэдэг. Бусдыг санаатайгаар алах, бага насны хүүхдийг хүчирхийлэх, алах, мөн эх орноосоо урваж терроризм хийх гэсэн ийм хэргүүд дээр бүх насаар хорих ялыг хэрэглэж явж байгаа.

Бүх насаар хорих ял нь 20 жил байгаа. 20 жилийн хугацаагаар хорих.

Одоо өнөөдөр бол бас нэлээн тийм түүхэн үйл явдал болж байна. Авлигатай тэмцэх ялын бодлогыг чангалах Засгийн газрын санаачилгыг дэмжиж байгаа. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, улс төрд нөлөө бүхий этгээд хахууль авах юм бол бүх насаар хоригдох ялтай болох гэж байна. Одоо манай Эрүүгийн хуульд байгаа ялын хамгийн дээд хэмжээ нь. Тултал нь чангалах гэж байна гэсэн үг. Ийм үйл явдал болж байна.

Гадаа иргэд маань энэ шударга ёсыг нэхэж шаардаж байна. 20, 30 жилд ямар хэмжээний хулгай болов, улс орноо тонон дээрэмдэв гэдэг асуудал тодорхой болж байна. Энд нөлөөлсөн нэг асуудал бол энэ ялын бодлого сул байсантай холбоотой. Авлигачид нь малын хулгайчаасаа хөнгөн ял шийтгэгддэг. Авлигачид нь танхайн гэмт хэргээсээ хөнгөн ял шийтгэгддэг ийм ялын бодлоготой байсан учраас Монголд шударга ёс алдагдсан.

Тийм учраас ялын бодлогыг тул нь чангалах Засгийн газрын санаачилга, энэ хуулийн төслийг дэмжиж байгаа гэдгийгээ илэрхийлье.

Л.Мөнхбаатар: Ш.Раднаасэд гишүүн хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлнэ.

Ш.Раднаасэд: 2012 онд тэр Чалкогийн гэрээ гэж байгуулагдаад Тавантолгойн захирал байсан Б.Энэбиш гэж хүн зугтаагаад алга болсон.

Тэгээд 250 сая долларын хэрэг алга болсон. Дараа нь Я.Батсуурь гэж хүн очоод. Тавантолгой дээр. Бас л байгалийн баялаг шүү дээ. Бас очоод нэг ял шийтгэл хүлээсэн болоод. Тэгээд Д.Ариунболдын дараа нь барьсан. Одоо энэ Б.Ганхуягийг нь барьж байна.

Ерөөсөө энэ байгалийн баялаг тойрсон их хэмжээний хулгай луйвар чинь хийж болох юм байна гэдэг л энэ ялын нөхцөл байдлыг чинь харахад тэгж байгаа шүү дээ. Үүнээс чинь зугтааж чадаж байна. Болж байна.

Одоо тэр зугтаах замыг нь бүрэн хаачихсан юм хаана байгаа юм. Б.Энхбаяр гишүүний хэлээд байгаа энэ хаана бүх насаар нь хорино гэсэн юм байгаа юм. Би ерөөсөө хайгаад олсонгүй.

Энэ чинь албан тушаалаа урвуулан ашиглах 5 жилтэй, тэр 22.1 чинь бас л 5 жил нь хэвээрээ л байна шүү дээ. Нөгөө 40 саяыг нь л авч хаясан болохоос. Тийм. Одоо энэ байдал чинь яах юм бэ. Энэ улстөрчид чинь л хийж байгаа шүү дээ. Ер нь бол. Энэ байгалийн баялаг.

Энэ эзэмшиж байгаа лицензүүд нь, энэ хөрөнгө орлого нь өсөж байгаа юмнуудаа яаж үзэх юм. Зүгээр хөрөнгийг нь хураасан болоод өө би өгнө өө гээд ингээд нэг хөрөнгө хураалгахаа илэрхийлчихвэл тэгээд л болчих юм биш үү. Тэгээд 5 жил хүртэлх ял биш бол бүгд ялаас чөлөөлөгдөөд л ингээд л жаргаад явах нь байна шүү дээ.

Энэ чинь хэдэн их наядын тоо тооцоо явж байна гээд биз дээ? Одоо жишээлбэл тэр “Бодь групп” гээд тэр Голомтын тэрийг яах юм.

Суурь тавьчихсан зам дээр орж хэдэн сая доллар ч хийсэн юм. Хийгээгүй ч юм ч юм уу. Тэрбум долларын ашиг хийдэг. 300 километр зам дээр тэрбум долларын ашиг хийдэг гэж юу байдаг юм бэ. Хамгийн бага нь. 1.5 тэрбум долларын ашиг.

Тэгээд одоо яах вэ энэ хүн. Одоо төрд учирсан хохирол чинь энэ ээ. За уучлаарай гээд нэг хэдэн төгрөг өгөөд ингээд явах уу.

Энэ бол зүгээр л амь аргацаасан ийм юм байна. Хийвэл энэ дээр бүгдийг нь тэр ялын дээд хэмжээгээр нь явуул. Тэгж байж энэ чинь зогсоно. Энэ айдасгүй албан тушаалтан гэдэг бол араатнаас илүү араатан байхгүй юу. Айдасгүй учраас энэ хүмүүс чинь юм хийгээд байгаа юм.

Энэ Орос, Хятад хоёр яагаад өнөөдөр авлигаас бүрэн салаад байгаа юм. Эрүүгийн хуулийнх нь ялыг нь харьцуулсан юм та нарт өнөөдөр байна уу. Ялангуяа энэ албан тушаал, хэзээ хахуулийн хэрэг дээр. Тийм хэмжээнд нь чангалж чадахгүй зүгээр өнөөдөр байгаа ард иргэдийн яриад байгаа 40 сая гэхээр нь 40 саяыг нь хасаад ингээд оруулаад ирчихсэн. Ийм байдалтайгаар юм явахгүй л дээ.

Энэ бүр сайжруулах биш муужруулчихсан юм болов уу. Би үүнийг өнөөдөр төр дахиад үзнэ. Маргааш чуулганаар орвол энэ дээр ярина.

Албан үүргийн хувьд үүнийг тухайн албан тушаалыг хариуцдаггүйн төлөө энэ хүмүүс ялаас чөлөөлөгдөх юмнууд байна шүү дээ. Одоо жишээлбэл энэ ТУЗ-ийн гишүүд яах юм. Энэ ТУЗ томилдог албан тушаалтнууд яах юм. Гарын үсэг зураагүй. Би хахууль аваагүй. Тэгээд эрүүгийн хариуцлагаас энэ хүмүүс чинь сугараад угтаад үлдчихэж байна шүү дээ.

Тэгээд энэ юмнуудаа энэ дотроо хийхгүй юм уу. Хэдэн жил энэ баялгийн хараал гэж юманд өртөж бид ингэж энэ ард түмнийг ийм байдалд амьдруулах юм бэ.

Энэ хуулиа чангалбал чангалсан шиг чангалаад хүн байтугай хулгана орох зайгүй болго л доо. Энэ хулганууд чинь орж ирээд гэрийг чинь түвээж байна шүү дээ. Одоо үүгээр хулганы нүх бөглөнө гэж байгаа бол бөглөгдөх ч үгүй юм байна.

Одоо 5 нэр гаргаад шидчихсэн. Энэ 5-аар ингээд жагсаалыг тараагаад, үүгээр ингээд хулганы нүхээ бөглөөд бид сайхан болчихлоо гэх гэж байгаа бол энэ чинь бол тэгж харагдахгүй байна. Тэгж харагдахгүй байна.

Түрүүн хөнгөн хийсвэр сэтгэл хөдлөлөөр хандаж болохгүй гэдгийг хэлж байна. Бодлоо гүйцээж Эрүүгийн хууль бичдэг гэж би анх Эрүүгийн хууль хийж байхад чинь ажлын хэсгийг ахалж байхад чинь өөрт чинь хэлж байсан. Энэ ялын бодлого чинь арай олон болчихоод байна шүү. Сонгох санкц чинь гэж. Тэр Байнгын хорооны анхны хэлэлцэх эсэхийг шийдсэн хурлын протоколыг та нар шүүгээд үзээрэй. Албан тушаалын гэмт хэрэг дээр энэ сонгох санкц олноор орохоор шүүх хамгийн хөнгөнөөр нь яллаад байна. Төвийн сонгох санкцуудаа болиод бүгдийг нь хорих болго л доо.

Ингэхгүйгээр энэ бол зүгээр ингээд нүд хуурсан, өнгө будгийн ийм ажил хийх гэж байгаа бол энэ бол явахгүй. Би энэ жагсагчдыг битгий тараарай. Энэ бол худлаа явж байна гэж хэлнэ.

Ийм байдлаар Эрүүгийн хуулийн яг энэ албан тушаалын эрхийг оролдох гэж байгаа бол энд өөдтэй юм алга. Яг гарын үсэг зурдаг. Одоо жишээлэх юм бол агентлагийн дарга, Төрийн нарийн, тэр улсын үйлдвэрийн газрын дарга нар дээр л хариуцлагыг нь нэмсэн болохоос энэ улс төрийнхнийхөө хариуцлагыг огт нэмээгүй байна наадах чинь. Огт нэмээгүй байна. Харин шүүмжлээд байгаа юмнуудыг нь харин аваад хаячхаж.

Л.Мөнхбаатар: Ш.Адъяаа гишүүн хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлье.

Ш.Адъяаа: Өнөөдөр энэ яаралтай горимоор орж ирсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах, нэн ялангуяа авлигал, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх Засгийн газрын өргөн мэдүүлсэн хуулийг өнөөдөр хэлэлцэж батлах нь өнөөдөр нийгэмд үүсээд байгаа нөхцөл байдал, энэ шударга ёстой тэмцэх Монгол төрийн үүрэг байх ёстой.

Тэгэхдээ үүнийг бид өнөөдөр гадаа байгаа нөхцөл байдалтай холбогдуулж энд зориулсан байдлаар хийнэ гэвэл бас учир дутагдалтай шүү. Энд олон талаас нь бид нарийн сайн ярьж байж үүнийг батлах ёстой.

Хууль гэдэг бол өнөөдөр нэг үйл явдалд зориулж, нэг асуудлыг шийдэхийн тулд хийдэг ийм зүйл биш ээ. Өнөөдөр Монгол Улс ардчилсан Монгол Улс. Эрх зүйт төртэй. Эрх зүйн үзэл бодол, баримтлал, онол дээр тулгуурласан ийм олон зүйлүүдийг тавих ёстой.

Албан тушаалын гэмт хэрэг, улс төрийн албан тушаалтан, нийтийн албан тушаалтан, төрийн өндөр албан тушаалтнууд өнөөдөр хариуцлага хүлээлгэх асуудал байх ёстой. Үүнийг шийдэх ёстой. Ялын бодлогыг чангатгах ёстой. Энэ дээр санал нэг байгаа. Гэтэл өнөөдөр энэ авлига, албан тушаалтны гэмт хэрэгт дөхөм үзүүлсэн хамтран оролцсон, ялангуяа дэлхийд байхгүй тэр offtake гэрээ гэдэг юманд оролцсон энэ банк, санхүүгийн бүлэглэлүүдийн тухай асуудал нь энд яагаад тодорхой хэмжээгээр орж ирэхгүй байгаа юм. Энд чинь байхгүй байна шүү дээ. Энэ хүмүүсийн асуудлыг яах юм.

Нөгөө авлига албан тушаалыг өгсөн тэр улс төрийн албан тушаалтнууд, тэгээд эд нар нь ингээд ял зэмээ аваад явдаг юм байж. Энэ нөхцөл байдлыг үүсгэсэн ийм хүмүүстэй тооцох хариуцлага аль зүйл ангид оруулах юм гэдгийг бид бас ярьж шийдэх ёстой. Энэ дээр бид өнөөдөр шүүх хуулийн өмнө тэгш байх, гэмт хэргийг гарах нөхцөл байдлыг үүсгэсэн, ийм нөхцөл байдлыг бий болгосон, өөрт байгаа давуу байдлаа ашигладаг ч гэх юм уу, үүгээр далимдуулж тухайн улс төрчдийг, албан тушаалтнуудыг зохион байгуулалтад оруулсан энэ хүмүүсийн тухай асуудлуудыг аль зүйл ангид нь оруулах юм, яаж шийдэх юм гэдэг энэ асуудлыг бас давхар дараа дараагийн хэлэлцүүлэгт оруулах ёстой гэсэн ийм бодолтой байгаа.

Яагаад гэвэл өнөөдөр гэмт хэргийг гаргах нөхцөлийг бид хаах гэж байгаа юм. Үүнийг бид цаашид гаргахгүй байх энэ нүх сүвийг хаах гэж байгаа юм. Бид цаашдаа энэ хуулийн хүрээнд тогтолцооны өөрчлөлт хийх, энэ мөрдөн шалгах үйл ажиллагааны нөхцөлд үүссэн, тогтоогдсон нөхцөл байдлууд дээр бид бас дүгнэлт хийж, бусад зүйл ангиудыг нь ч гэсэн энд хөндөх ийм зайлшгүй шаардлага байгаа гэдгийг энд хууль тогтоогчийн хувьд саналаа хэлье.

Ингээд энэ хуулийг яаралтай гаргах нь маш зөв шийдэл болно гэдэг дээр санал нэг байгаа. Энэ хуулийг баталж гаргахыг дэмжиж байгаа.

Засгийн газраас оруулж ирсэн энэ саналууд дээр манай энэ хууль тогтоогчид, бас энэ шинжээчид, түүнчлэн тэр Б.Энхбаяр гишүүний ярьж байгаа прокурор, шүүхийн байгууллагуудыг бас дараагийн хэлэлцүүлэг дээр, Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр энд оруулж ирж үүнийг шийдэх ёстой.

Түүнчлэн энд зав цаг гаргаад Хууль зүйн байнгын хороо ч юм уу, бас тодорхой судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд тодорхой санал хэлэлцүүлэг хийхэд ч болохгүй юм байхгүй шүү дээ.

Түүнчлэн нөгөө талаас бас бид аливаа юманд бид бас болгоомжтой хандах ёстой. Бид бол Монгол Улсын өмнө хүлээсэн үүрэг, авлигын конвенцийн өмнө

хүлээсэн үүрэг, хүний эрхийн түгээмэл тунхаглалын өмнө хүлээсэн үүрэг гэж байгаа.

Үүнтэй уялдуулж бид бас өнөөдөр үүнийг нэг үйл явдалд зориулж ийм том асуудлыг шийдэх Эрүүгийн хууль дээр бид бас олон талаас нь шүүж, харж, хэлэлцэж байж шийдэх нь нийт Монголын эрх ашиг, нийт хууль дээдлэх зарчмын эрх ашиг, хууль шүүхийн өмнө тэгш байх эрх ашиг, шударга шүүхээр шүүлгэх эрх ашиг байх гэдэг дээр бид бодолцох ёстой гэсэн ийм л байр суурьтай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ш.Адъяаа гишүүн дэмжиж үг хэллээ.

Б.Энхбаяр гишүүн, Ш.Адъяаа гишүүн нар хөндөж тавьсан. Маргаашийн нэгдсэн чуулганаар уг хуулийг хэлэлцэх хэлэлцүүлгийн явцад Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор, мөн зарим энэ чиглэлээр мэргэшсэн судлаачдыг. Б.Батзориг доктор байна. Энд манай ажлын хэсэгт ажиллаж байгаа докторууд ажиллаж байгаа. Эдгээр дээр нэмж шаардлагатай бол нэмээд ингээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хурлаар хэлэлцүүлэхэд байлцуулья гэдгийг Байнгын хорооны ажлын албанд даалгая.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулья. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

Уг төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 71.4 хувь нь дэмжсэн байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Санал, дүгнэлтийг нь би уншчихья даа.

БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД